

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗӨВЛӨМЖ

2009 оны 11 сарын 30-ны өдөр

дугаар 01

Улаанбаатар хот

Анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах, гомдлыг хүлээн авах шүүхийн ажиллагаа

Анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах, гомдлыг хүлээн авах шүүхийн ажиллагаанд гарч буй нийтлэг алдааг судалж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 161-164 дүгээр зүйлүүдэд заасан журмыг хэрэгжүүлэх нэгдсэн аргачлалыг шүүгч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарт олгох, хуулийн дээрх зохицуулалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэгжүүлэх зорилгоор Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3., 15.4. дэх хэсгийг үндэслэн Улсын Дээд Шүүхээс **ЗӨВЛӨМЖ** болгох нь:

Нэг. Анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т “Шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй” гэсэн нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч иргэн, хуулийн этгээдэд хамааралтай бөгөөд энэхүү заалт нь тэдгээрийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг шүүх хамгаалах бодит баталгаа мөн.

Анхан шатны шүүхийн шийдвэр нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.2.-т зааснаар “Шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх” шаардлагыг хангасан байх учиртай. Иргэний хэргийн оролцогчид Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу анхан шатны шүүхийн шийдвэрийг хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангаагүй гэж үзсэн тохиолдолд давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй бөгөөд давж заалдах шатны шүүх нь уг гомдол үндэслэлтэй эсэхийг анхан шатны шүүхийн шийдвэрийг холбогдох хэргийн хамт хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянасны үндсэн дээр шийдвэрлэдэг.

Ийнхүү иргэн, хуулийн этгээд нь анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах нь нэг талаас тэдгээр нь шүүхээр хамгаалуулах эрхээ эдлэх, нөгөө талаас давж заалдах шатны шүүх хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд анхан шатны шүүхийн алдаатай шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох замаар залруулах ач холбогдолтой юм.

1. Шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах болон гомдол гаргах эрх бүхий этгээдийн талаар.

1.1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 161 дүгээр зүйлийн 161.1.-д заасан “шүүхийн шийдвэр” гэдэгт энэ хуулийн 115, 116, 118 дугаар зүйлд заасан журмын дагуу гарсан шийдвэрийг ойлговол зохино.

1.2. Мөн зүйлийн “зохигч, гуравдагч этгээд,” гэдэгт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 26, 29 дүгээр зүйлд заасан иргэн, хуулийн этгээдийг ойлгох бөгөөд эдгээр нь Иргэний хуулийн 15 дугаар зүйлийн 15.1., 15.2.-т зааснаар эрх зүйн бүрэн чадамжтай этгээдүүд, өөрөөр хэлбэл тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч байна. Харин “тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч” гэдэгт Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32, 33, 34 дүгээр зүйлд зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэнийг төлөөлж буй этгээд, хуульд зааснаар төлөөлж буй этгээд, Өмгөөллийн тухай хуульд заасан үйл ажиллагаа явуулах бүрэн эрхтэй мэргэжлийн өмгөөлөгчийг ойлгоно.

1.3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан прокурор, бусдын эрхийг хамгаалж байгаа этгээд нь анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.6.-д зааснаар давж заалдах гомдол гаргах эрхтэй байна.

1.4. Харин хуулийн этгээдийг хуульд зааснаар төлөөлөх эрхгүй буюу итгэмжлэлгүй этгээд давж заалдах гомдол гаргах эрхгүй юм. Анхан шатны шүүх давж заалдах гомдол гаргаж буй төлөөлөгчийн бүрэн эрхийг итгэмжлэлийн хүрээнд байгаа эсэхийг сайтар шалгавал зохино.

1.5.Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч шүүх хуралдаанд биечлэн оролцсоноос үл хамааран давж заалдах гомдол гаргах эрхтэй байна.

Хоёр.Давж заалдах гомдлын хэлбэр, агуулга

2.Давж заалдах гомдлын хэлбэр, агуулгын талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 162 дугаар зүйлд нарийвчлан зохицуулсан журмыг давж заалдах шатны шүүх дагаж мөрдөнө. Үүнд:

2.1.Давж заалдах шатны шүүх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлийн 166.4.-т зааснаар зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзэх бүрэн эрхтэй, өөрөөр хэлбэл хянагдаж буй тухайн шийдвэр нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх талаас нь бүхэлд нь хянан шийдвэрлэдэг онцлогтой учир давж заалдах шатны шүүх хянагдаж буй шийдвэрийн үндэслэл болон тогтоох хэсэгт тусгагдсан үндэслэл, түүнийг нотолж буй нотлох баримтыг бүрэн дүүрэн үнэлэхэд давж заалдах гомдлын агуулга чухал ач холбогдолтой байдаг.

2.2.Давж заалдах гомдлын агуулга нь анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч буй үндэслэл, ямар нотлох баримтыг зөвшөөрөхгүй байгаа, давж заалдах шатны шүүхэд гаргасан хүсэлт, тэдгээрийн эрх зүйн үндэслэлийг багтаасан байхыг анхаарвал зохино.

2.3.Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2007 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 62 дугаар тогтоолоор батлагдсан “Хэргийн хөдөлгөөний стандарт”-д тусгагдсан шаардлагын дагуу гомдлын хэлбэр болон агуулгыг шүүх хянан шалгана.

2.4.Давж заалдах гомдол бичгийн хэлбэртэй байх ба уг гомдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 162 дугаар зүйлийн 162.2.1.-162.2.3., 162.3.-т заасан мэдээлэл, шаардлагууд бүрэн тусгагдсан эсэхийг шүүх анхаарч, хуульд заасан аль нэг мэдээлэл, шаардлага дутуу байх тохиолдолд шүүх гомдлыг хүлээн авахаас татгалзах учиртай боловч уг зөрчлийг арилгахад бэрхшээлтэй биш, эсхүл тухайн зөрчлийг засах боломжтой бол шүүх хэргийн оролцогчоор өөрөөр нь дутуу зүйлийг бүрдүүлүүлж болно.

Гурав.Давж заалдах гомдол гаргахад төлөх улсын тэмдэгтийн хураамжийн тухай

3.Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч давж заалдах гомдол гаргахдаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 162 дугаар зүйлийн 162.4.-т заасан хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамж төлөх бөгөөд дараах зүйлийг анхаарна:

3.1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1.-д заасны дагуу давж заалдах гомдол гаргаж буй зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлнө.

3.2.Гомдол гаргагч нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4.-т зааснаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа хэмжээгээр, өөрөөр хэлбэл нэхэмжлэлийн шаардлагыг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг нь зөвшөөрөхгүй байгаа тэр хэсэгт ногдох улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлнө.

3.3.Дээрх заалт сөрөг нэхэмжлэлд мөн хамааралтай байна.

3.4.Нэхэмжлэл болон сөрөг нэхэмжлэл хэд, хэдэн шаардлагыг агуулсан бол гомдол гаргагч зөвшөөрөхгүй байгаа шаардлагад тохирох улсын тэмдэгтийн хураамжийг Тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан хэмжээгээр урьдчилан төлнө.

3.5.Давж заалдах гомдол гаргагч төлбөрийн чадваргүй болох нь нотлох баримтаар хангалттай тогтоогдсон, тухайлбал иргэний хувьд нэн ядуу, хүнд байдалд амьдарч байгааг тодорхойлсон засаг, захиргааны нэгжийн тодорхойлолт, харин хуулийн этгээдийн хувьд Татварын байгууллагын тодорхойлолт болон санхүүгийн тайлан зэрэг холбогдол бүхий бусад нотлох баримт бүрдсэн тохиолдолд түүнийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 58 дугаар

зүйлийн 58.3.-т зааснаар улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс анхан шатны шүүх шүүгчийн захирамжаар чөлөөлж болно. Харин гомдол гаргагчийн төлбөрийн чадваргүй эсэх нь тогтоогдоогүй, өөрөөр хэлбэл холбогдох нотлох баримтгүй байхад түүнийг улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс чөлөөлж болохгүйг анхан шатны шүүхүүд анхаарвал зохино. Нэхэмжлэл гаргахад улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдсөн явдал давж заалдах гомдол гаргахад дахин хүсэлт гаргахаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

3.6. Давж заалдах гомдол гаргагчийн эд хөрөнгийн буюу тухайн үед улсын тэмдэгтийн хураамж төлөх боломжгүй байдлыг харгалзан анхан шатны шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.4.-т заасны дагуу шүүгчийн захирамжаар улсын тэмдэгтийн хураамж төлөх хэмжээг багасгах буюу хугацааг хойшлуулах, эсхүл хэсэгчлэн төлүүлэх арга хэмжээ авч болно.

3.7. Тэмдэгтийн хураамжийн хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу нэхэмжлэл гаргахад улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс чөлөөлөгддөг зохицуулалт давж заалдах гомдол гаргахад мөн адил үйлчлэх ба хураамжаас чөлөөлөгдөх этгээдийг шүүх зааглан ялгах шаардлагатай. Тухайлбал гомдлоор үүсэх хэрэгт нэхэмжлэгч хураамжаас чөлөөлөгддөг бол ийнхүү чөлөөлөгдсөн этгээд давж заалдах гомдол гаргавал мөн хураамжаас чөлөөлөгдөх үндэслэлтэй болохоос хариуцагч хуульд заасан өөр үндэслэл байгаагаас бусад тохиолдолд хураамжаас чөлөөлөгдөхгүй.

Дөрөв. Давж заалдах гомдлыг хүлээн авах

4. Анхан шатны шүүх давж заалдах гомдлыг хүлээн авахдаа дараах зүйлийг баримтална.

4.1. Давж заалдах гомдлыг шийдвэр гаргасан анхан шатны шүүх хүлээн авч, давж заалдах гомдлын нэгдсэн бүртгэлд авна.

4.2. Давж заалдах гомдлыг хүлээн авч буй албан тушаалтан гомдол хуульд заасан хугацаанд гарсан эсэхийг шалгана. Үүний тулд гомдол гаргагч шүүхийн шийдвэрийг хэзээ хүлээн авсныг нягталж үзнэ.

4.2.1. Анхан шатны шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.4., 119.5.-д заасан журмыг баримтлан шийдвэрийг давж заалдах гомдол гаргах эрх бүхий этгээдэд гардуулан өгөх буюу шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар хүргүүлэх үүрэгтэй бөгөөд гомдол гаргагчийн шийдвэр хүлээн авсан өдрийг шүүхээс шийдвэр гардуулан өгсөн баримт, харилцаа холбооны газрын шуудан хүргэсэн албан бичиг, шүүхийн ажилтны бүртгэлийн дэвтрийн хуулбар зэргээр нотолсон байх шаардлагатай.

4.2.2. Түүнчлэн шүүхийн шийдвэрийг хүлээн авах этгээд оршин суугаа газартаа буюу ажлынхаа газарт байхгүй бол уг шийдвэрийг түүний хамт амьдардаг насанд хүрсэн иргэн, эсхүл сум, баг хорооны Засаг дарга, түүний ажлын албанд буюу захиргаанд, мөн хуулийн этгээдийн хувьд тухайн байгууллагын удирдлага, албан тушаалтанд хүлээлгэн өгч гарын үсэг зуруулсан өдрөөс гомдол гаргах хугацааг тоолно.

4.2.3. Хэрэв хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа үед хэргийн оролцогч хаягаа өөрчилсөн бол шүүхэд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй этгээдийн сүүлчийн хаягаар хүргүүлж, тухайн хаягт байгаа насанд хүрсэн иргэн, холбогдох албан тушаалтанд өгснөөр давж заалдах гомдлын хугацааг эхлэн тооцож болно.

4.2.4. Шүүх нь шийдвэрийг зохигч, түүний төлөөлөгч, өмгөөлөгчийн аль нэгэнд гардуулан өгснөөр давж заалдах гомдлын хугацааг тоолно. Хэргийн оролцогчийн төлөөлөгч, өмгөөлөгч шийдвэрийг хүлээн авсан өдрийг хэргийн оролцогчийн хүлээн авсан өдөр гэж үзнэ.

4.3. Давж заалдсан гомдлын хугацаа нь Иргэний хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.-т заасан “Үүргийг ямар нэгэн байгууллагад гүйцэтгэх ёстой байсан бол зохих журмаар тогтоосон уг байгууллагын ажлын өдөр буюу үйлдвэрлэлийн ажиллагаа дуусах эцсийн цагийн дотор гүйцэтгэнэ” гэсэн зохицуулалтанд хамаарна. Өөрөөр хэлбэл, гомдол гаргагч шүүхийн шийдвэрийг хүлээн авсан өдрөөс тоолж, хуульд заасан эцсийн өдөр гомдол гаргахад түүний анх авсан өдрийн цаг, минутаар бус харин ажлын цаг дуусах буюу 18 цагаас өмнө шүүхэд ирүүлсэн байна.

4.4. Давж заалдах гомдол гаргах эрх бүхий этгээд нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуульд заасан 14 хоногийн хугацааг хэтрүүлж, гомдол гаргасан ба энэ хугацааг сэргээлгэх тухай шүүхэд хүсэлт ирүүлсэн бол хэргийг шийдвэрлэсэн анхан шатны шүүх Иргэний хуулийн 82 дугаар зүйлийн 82.4.-т заасны дагуу давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээж, шүүгч захирамж гаргана.

“Хүндэтгэн үзэх шалтгаан”-тай байснаа гомдол гаргагч нотлох үүрэгтэй бөгөөд уг шалтгаан нь хангалттай нотлох баримтаар тогтоогдсон нөхцөлд шүүх гомдол гаргах эрхийн хугацааг сэргээх тухай шүүгчийн захирамж гаргана.

4.5. Давж заалдах гомдол гаргасан этгээд нь хуульд заасан гомдол гаргах этгээд мөн эсэхэд анхаарна.

4.6. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4., Тэмдэгтийн хураамжийн хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамж төлсөн эсэхийг шалгана.

4.7. Давж заалдах гомдолд гомдол гаргасан этгээд гомдолдоо гарын үсэг зурсан, хуулийн этгээдийн хувьд тамга дарж баталгаажуулсан зэргийг нягтлан үзнэ.

4.8. Дээрх шаардлагыг хангасан давж заалдах гомдлыг хүлээн авч, тэмдэг дарж баталгаажуулан, хүлээн авсан он, сар, өдөр, цаг, минутыг тодорхой бичнэ.

4.9. Гомдлыг хүлээн авсан шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүгчийн туслах нь зохигч, тэдгээрийн төлөөлөгчийн аль нэгэнд гомдлыг нэн даруй танилцуулж, тайлбарыг авна. Давж заалдах гомдолтой танилцсан зохигч, түүний төлөөлөгч нь шүүх гомдлыг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор шүүхэд тайлбараа ирүүлсэн байхыг шүүхийн зүгээс тэдгээрт анхааруулах нь зүйтэй.

4.10. Гомдол хүлээн авсан шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 163 дугаар зүйлийн 163.3.-т заасан хугацаанд давж заалдах шатны шүүхэд хүргүүлбэл зохино.

Тав. Давж заалдах гомдлоос татгалзах, шүүх гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай

5.1. Давж заалдах гомдол гаргасан этгээд давж заалдах шатны шүүх хуралдаанаас өмнө гомдлоосоо татгалзсан бол шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.3.-т заасан журмаар “гомдол гаргаагүйд” тооцож, шүүгч захирамж гаргана. Гомдол гаргагчийн хүсэлт нь заавал бичгийн хэлбэртэй байна.

5.2. Давж заалдах гомдол гаргасан этгээд шүүхэд гаргасан гомдлоосоо татгалзсан тохиолдолд шүүх түүний төлсөн улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгох бөгөөд энэ талаар шүүгчийн захирамжинд заавал тусгана.

5.3. Давж заалдах гомдол нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 162 дугаар зүйлд заасан шаардлагын аль нэгийг хангаагүй тохиолдолд шүүгч “гомдлыг хүлээн авахаас татгалзаж”, захирамж гаргана.

5.4. Давж заалдах гомдол нь шүүхийн шийдвэрт заасан гуравдагч этгээдийн эрх, ашгийг хөндсөн тохиолдолд тэдгээрт давж заалдах гомдлыг танилцуулах шаардлагатай.

Нийт шүүхүүдээс авсан судалгаанаас үзвэл давж заалдах гомдлыг хүлээн авах ажиллагаанд доор дурдсан дутагдал оршиж байгааг анхаарах нь зүйтэй.

Тухайлбал:

-Хуульд заасан хугацаанд давж заалдах шатны шүүхэд хэргийг хүргүүлэхгүй байх,
-улсын тэмдэгтийн хураамж дутуу, илүү төлүүлэх, ийнхүү илүү, дутуу төлсөн байгааг нягтлан шалгахгүй байх,

-хуульд заасан үндэслэлгүйгээр давж заалдах гомдлыг хүлээн авахгүй татгалзах,

-Хугацаа хэтэрсэн гомдол хүлээн авах.

-зохигчийн өмгөөлөгч шийдвэрийг хүлээн авсан байхад зохигч өөрөө шийдвэрийг гардан аваагүй гэх үндэслэлээр давж заалдах хугацаа өнгөрсний дараа гаргасан гомдлыг хүлээн авах зэрэг зөрчил дутагдал түгээмэл гардаг тул шүүхүүд ажлын зохион байгуулалт, хариуцлагыг

дээшлүүлж, үйл ажиллагаагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж байхыг анхааруулж байна.

ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ